

## ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ГАДААД, ДОТООД ОРЧНЫ ХУВЬСАЛ ӨӨРЧЛӨЛТ, БОЛЗОШГҮЙ АЮУЛ, СОРИЛТЫН ТУХАЙ ТӨСӨӨЛӨЛ

П.Мягмарсүрэн

МУИС-ийн Улс төр судлалын тэнхмийн магистрант

### Оршил

Дэлхий ертөнц хурдацтай хувьсан өөрчлөгдөж, хүн төрөлхтөнд хөгжлийн шинэ боломж нээгдэхийн зэрэгцээ шинэ сорилт бэрхшээл тулгарах болов. Ойрын ирээдүйд дэлхий нийтийн өмнө хүн амын өсөлтөөс үүдэн улс орнууд хүнс, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж чадах эсэх, үйлдвэрлэл нь улам бүр эмзэг болсоор байгаа байгаль орчинд ээлтэй байж чадах эсэх гэх мэт олон бэрхшээл, томоохон сорилтуудтай тулгарах магадлал өндөр байна. Хүнсний нийлүүлэлт, үйлдвэрлэл, усны хангамж, түүхий эд болон эрчим хүчний асуудалтай холбоотой улс хоорондын, нийгмийн бүлэг хоорондын зөрчил хурцдах төлөв ажиглагдаж байна.

НҮБ-аас улс орнуудын үндэсний аюулгүй байдалд шууд нөлөөлж болох зургаан төрлийн аюулыг дурдаж, эдгээр аюул ойрын үед ч, алс хэтдээ ч тулгарсаар байх учраас улс орнууд үндэсний аюулгүй байдлынхаа хүрээнд онцгой анхаарвал зохино хэмээн тэмдэглэжээ. Тэдгээр нь:

*Нэгд*, хүрээлэн буй орчны доройтол, халдварт өвчин, ядуурал нүүрлэсэн нийгэм, эдийн засгийн аюул, *Хоёрт*, улс хоорондын зөрчил, мөргөлдөөн, *Гуравт*, иргэний дайн нүүрлэсэн улс орны дотоод дахь зөрчил, *Дөрөвт*, цөм, хими, биологийн зэвсгийн аюул, *Тавд*, терроризм, *Зургаад*, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг зэрэг болно.

Нэгэнт Монгол Улсын аюулгүй байдал нь олон улсын аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг мөн тул үндэсний аюулгүй байдлын гадаад, дотоод орчны хувьсал өөрчлөлт, болзошгүй аюул, сорилт бэрхшээлийн тухай төсөөллөө хуваалцаж.

Нэг. Гадаад орчны хувьсал өөрчлөлт: аюул, сорилтын төсөөлөл

Олон улсын харилцааны шинэ тоглогчид:

Шинээр хүчирхэгжиж буй улсууд, даяаршсан эдийн засаг, “улс бус тоглогчид”-ын нөлөө нэмэгдэн, дэлхийн эдийн засгийн чадавхи өрнөөс дорно зүгт шилжиж буй зэргээс шалтгаалан өнгөрсөн зууны хоёрдугаар хагасаас бүрэлдэн тогтсон олон улсын харилцаа ойрын ирээдүйд ихээхэн өөрчлөгдөх нь тодорхой болов. Олон улсын харилцаанд томоохон өөрчлөлтүүд гарч, Өрнөдийн эрдэмтдийн үзэж байгаачлан олон улсын харилцаа хэд хэдэн туйлтай болж байна.

Үндэстэн дамнасан болон төрийн оролцоотой корпораци, компани, шашны байгууллага, гэмт бүлэглэлийн үйл ажиллагаа идэвхжиж, мөн дэлхий дахины цаашдын хөгжилд нөлөөлөхүйц хүчин зүйлсийн шинж чанар өөрчлөгдөж, аж үйлдвэржсэн болон хөгжиж буй орнуудад хүн ам, эрчим хүч, хүнс, ундны усны хомсдол зэрэг тулгамдсан асуудал үүсч, тэдгээрийг хамтын хүчээр шийдвэрлэх шаардлага урган гарч байна.


Өнөөдөр дэлхийн санхүү, эдийн засгийн тогтворгүй байдал олон улсын системийг бүхэлд нь эвдэхгүй ч ойрын ирээдүйд эрсдэлээр дүүрэн байх төлөвтэй байна. Стратегийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэхийн төлөөх улс гүрний өрсөлдөөн нь худалдаа, хөрөнгө оруулалт, технологийн дэвшилд ихээхэн анхаарахын зэрэгцээ цэрэг зэвсгээр хөөцөлдөн нутаг дэвсгэр, нөлөөллийн орон зайгаа тэлэхээр өрсөлдсөөр байна.

Олон улсын улс төр, эдийн засгийн харилцаанд АНУ нөлөө бүхий хүчирхэг гүрэн хэвээр байгаа ч Ирак, Афганистан дахь дайн, терроризмтой хийж буй тэмцэл, эдийн засаг, санхүүгийн хямрал зэрэг дотоод асуудал нь олон улсын хүчний тэнцвэрийг өөрчилж, “АНУ”, “Хятад”, “Орос”, “Ойрхи Дорнод” гэсэн олон туйлт систем рүү аажмаар шилжихэд хүргэж байна. Дэлхийн улс төр, бусад салбарын асуудлыг шийдэх нөлөө бүхий шинэ “тоглогч”-оор Бразил, Орос, Энэтхэг, Хятад улс тодорч байна.

Азид төдийгүй дэлхийд Хятадын нөлөө улам бэхжиж, эдийн засгийн чадавхиар ойрын ирээдүйд АНУ-ыг гүйцэх хандлагатай болов. Хятад-Америкийн харилцаанд АНУ G8-аас гадна G2 гэсэн томъёоллыг хэрэглэх болсон нь Хятадтай хөгжүүлэх хоёр талын харилцааг бусдаас онцгойлж байгаагийн илрэл юм.

ОХУ байгалийн нөөц баялагтаа тулгуурлан эдийн засгаа бэхжүүлж, дэлхийд улс төр, эдийн засгийн хүч нөлөөгөө сэргээхийг зорьж байгаа ч Оросын дотоодын бэрхшээл нь тус улсыг бүс нутаг, цаашлаад дэлхийд өөрийн ноёрхол, нөлөөллийг бэхжүүлэхэд хүндрэл учруулж байна.

Зураг 1. Их гүрнүүдийн хүчний харьцаа: 2010, 2025 онд.



Дэлхийн эдийн засаг: 2025 он гэхэд дэлхийн нийт үйлдвэрлэлийн хэмжээ 2005 оныхтой харьцуулбал 2 дахин нэмэгдэх, АНУ, Европын холбоо, Японы дэлхийн зах зээл дээрх давамгайлал буурах хандлагатай байгаа бөгөөд дээрх улсуудын дэлхийн зах зээл дээрх ноёрхол багассанаар хөгжиж буй улсуудын эзлэх хэмжээ нэмэгдэх юм. 2005 онд хөгжиж буй улсуудад дэлхийн нийт баялгийн 20 орчим хувь ногдож байсан бол 2025 он гэхэд энэ үзүүлэлт 34 хувь болж өсөх тооцоог судлаачид хийжээ.

Олон улсын харилцаанд гарч буй хүчний харьцааны өрнөөс дорно зүгт шилжих процесс үргэлжилж, Азийн Хятад, Энэтхэг, БНСУ зэрэг улсуудын үйлдвэрлэсэн баялаг Европын холбоотой эн зэрэгцэхүйц хэмжээнд очих аж. Дээрх улсууд дээр Япон, Тайланд, Индонез зэрэг улсуудын үйлдвэрлэсэн баялаг нэмэгдсэнээр Ази тивд үйлдвэрлэж буй баялгийн хэмжээ дэлхийн нийт бүтээгдэхүүний 30 орчим хувьтай тэнцэх бол Европын холбооны хувьд энэ үзүүлэлт 20 хувьтай байх төлөвтэй байна.

2010 онд Хятадын эдийн засгийн хэмжээ Японыг ардаа орхиж, дэлхийд 2 дугаарт бичигдсэн бол 2025 оноос өмнө Энэтхэгийн эдийн засгийн хэмжээ 6-д бичигдэж Итали, Франц зэрэг Европын томоохон эдийн засагтай улсуудыг давах хандлагатай байна.


2030 он гэхэд дунд орлоготой буюу жилд 4000-17000 ам.долларын орлоготой иргэдийн тоо 1 тэрбумд хүрэх бөгөөд үүний 90 орчим хувь нь хөгжиж буй улсуудад амьдрах тооцоог олон улсын байгууллагууд гаргажээ. Харин БНХАУ болон Азийн бусад хөгжиж буй орнуудад баян, ядуугийн ялгаа нэмэгдэж болзошгүйг эрдэмтэд анхааруулж байна. 2025 он гэхэд дэлхийн хэмжээнд явагдаж буй худалдааны эргэлтийн хэмжээ 2005 онтой харьцуулбал 2 дахин нэмэгдэх бөгөөд Европын холбоо дэлхийн хамгийн том экспортлогчийн статусаа алдаж, 2025 он гэхэд дэлхийн улсуудын экспортын хэмжээний 32 хувийг бүрдүүлэх хэмжээнд буурах бол Азийн улсуудын экспортын эзлэх жин 29 хувиас 35 хувь болж нэмэгдэх төлөвтэй.

Дэлхийн санхүү эдийн засгийн хүчин чадал өрнөөс дорно зүгт шилжиж, Ази тивд үйлдвэрлэл урьд байгаагүйгээр хөгжиж, Бразиль, Орос, Энэтхэг, Хятадын ДНБ-ний хэмжээ 2040-2050 онд "Их 7"-ийн ДНБ-тэй тэнцэнэ гэж судлаачид үзэж байна. Тэд Хятадыг ойрын 20 жилд дэлхийн хамгийн нөлөө бүхий гүрэн болно хэмээн үзэж, хэрэв БНХАУ эдийн засгийн өсөлтөө өнөөгийн төвшинд барьж чадвал 2025 он гэхэд дэлхийн хамгийн том эдийн засагтай орон болох тооцоог гаргажээ. Үүнээс гадна тус улс дэлхийн хамгийн том цэргийн хүч, түүхий эд импортлогч, энэ хэрээр дэлхийг хамгийн ихээр бохирдуулагч болох магадлалтай юм.

Энэтхэгийн хувьд эдийн засгийн хөгжлөө цаашид энэ хэвээр сааруулахгүй барихыг чармайж, олон туйлт ертөнцийг бий болгож, эдгээр туйлуудын нэг болохыг зорих бол ОХУ хүний хөгжил, эдийн засгийн төрөлжилтөд анхаарч дэлхийн зах зээлд өөрийн байр суурийг олж чадвал илүү чинээлэг, хүчирхэг бөгөөд өөртөө итгэлтэй улс болох боломжтой ажээ.

Эдгээр гурван улстай эн зэрэгцэн дэлхийн тавцанд гарч ирэхээр өрсөлдөж буй өөр улс одоогоор байхгүй боловч БНСУ, Сингапур, Индонез, Иран, Турк зэрэг улсуудын улс төр, эдийн засгийн чадавхи хурдтай нэмэгдэж байгааг мөн тэмдэглэх хэрэгтэй.

Зураг 2. Дэлхийн эдийн засгийн 2020 оны төсөөлөл




Дэлхийн эрчим хүчний хэрэглээ: Олон улсын эрчим хүчний агентлагийн тооцоолсноор ирэх 14 жилд дэлхийн эрчим хүчний хэрэглээ 50 хувиар нэмэгдэх аж. Ирээдүйд газрын тосны олборлолт дээд хэмжээндээ хүрч, эрчим хүчний гол эх үүсвэр нь нүүрс болох ч 2025 онд газрын тос хамгийн чухал эх үүсвэр хэвээр байх аж. 2010-2030 онд хатуу түлшнээс дэлхийн эрчим хүчний 80 орчим хувийг гаргах бол цөмийн эрчим хүч болон сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээс тус бүр 10 хувийг гаргах тооцоог хийсэн байна. Өнөөдөр, дэлхийн эрчим хүчний 16 хувийг цөмийн реакторууд үйлдвэрлэж байна. 2010 оны байдлаар дэлхий дээр 438 цөмийн реактор ажиллаж, нийтдээ 374.127 MWe эрчим хүч үйлдвэрлэж, жилд 68.646 тонн уран хэрэглэж байжээ. Мөн 54 реакторын барилгын ажил үргэлжилж, 148 реакторын барилга төлөвлөлтийн шатандаа, 342 реактор судалгааны шатандаа байгаа тухай World Nuclear Association байгууллага тэмдэглэсэн байна. Хэрэв ураныг одоогийн хэрэглээний төвшинд хэрэглэсээр байвал энэ нь дэлхийн эрчим хүчний хэрэгцээг 85 жил хангах нөөц гэж ОУАЭА тооцоолсон байна.

Ашигт малтмалын салбар ойрын ирээдүйд дэлхийн улс орнуудын хөгжил, харилцаа, хамтын ажиллагааны гол сэдэв байх ба өдгөө дэлхийн хамгийн томд тооцогдох ашигт малтмалын ордуудын 50 орчим хувь нь ядуу буурай улсууд буюу нэг хүнд өдөрт ногдох ДНБ-ний хэмжээ нь 10 ам.доллар хүрэхгүй улсуудад ногдож байгаа аж.

Хөгжиж буй орнууд аж үйлдвэржихийн хэрээр тэдгээрийн түүхий эдийн хэрэглээ өсөх, түүхий эдийн олборлолтын хэмжээ ойрын жилүүдэд үлэмж нэмэгдэх хандлагатай байна. Хүн амын өсөлтөөс үүдэлтэй эрчим хүчний хэрэглээний өсөлт, газрын тосны нөөц шавхагдаж буй зэрэг хүчин зүйлээс үүдэн эрчим хүчний хангамжийн асуудал ойрын ирээдүйд дэлхий нийт, тэр дундаа их гүрнүүд болон хурдацтай аж үйлдвэржиж буй орнуудын удирдагчдын анхаарлын төвд байх ажээ.

Зураг 3. Дэлхийн эрчим хүчний хэрэглээ: 2030 он хүртэлх төсөөлөл


### Дэлхийн эрчим хүчний эх үүсвэрийн хэрэглээ



Хүн амын өсөлт: НҮБ-аас гаргасан судалгаагаар 2025 он гэхэд дэлхийн хүн ам ойролцоогоор 20 хувиар өсөх хандлагатай байгаа ба энэ өсөлтийн 97 хувь нь Ази, Африкийн хөгжиж буй орнуудад явагдах төлөвтэй байна. Судлаачид дэлхийн хүн ам 2025 он гэхэд 8 тэрбумд хүрэх тооцоог гаргажээ. 2025 онд дэлхийн нийт хүн амын 61 орчим хувь нь Ази тивд амьдрах тооцоог НҮБ гаргаад байна. Энэ хугацаанд Энэтхэгийн хүн ам Хятадын хүн амын тоонд дөхөж очих ба Ази тивийн хүн амын өсөлтөд Өмнөд Ази хамгийн их нөлөө үзүүлэх аж.

Халдварт өвчний тархалт хөгжиж буй орнуудыг түгшээсэн асуудал болоод байна. 30 жилийн өмнө байгаагүй 40 орчим өвчин өдгөө шинээр бий болжээ. ДЭМБ-ын мэдэгдсэнээр сүүлийн 5 жилд дэлхий дахинд 1000 орчим гоц халдварт өвчин гарсан байна. Хэрэв энэ хандлага цаашид хэвээр үргэлжилбэл 2025 он гэхэд ДОХ-ын халдвар тээгч иргэдийн тоо 33 саяас 50 сая болж өсөх магадлалтайг эрдэмтэд анхааруулсан байна.

Зураг 4. Дэлхийн хүн амын өсөлт: 2025 он хүртэлх төсөөлөл



Цэвэр усны хомсдол: Судлаачид ойрын ирээдүйд галлон цэвэр усны үнэ галлон бензиний үнээс давна, тэр мөчөөс эхлэн ундны цэвэр ус хамгийн чухал бизнес болно гэж үзэж байна. Манай дэлхий 1366 сая шоо км усны нөөцтэй. 7 тэрбум хүн амтай дэлхийд нэг хүнд ойролцоогоор 195 сая шоо км ус ногдоно. Гэвч үүний 97 хувь далайн шорвог ус, үлдсэн 3 хувь нь цэвэр усны нөөц бөгөөд үүний аравны ес нь мөс, 47 мянган шоо км нь ашиглахад төвөгтэй газрын доорх ус аж.

ЮНЕСКО-ийн илтгэлд тэмдэглэсэнээр 2023 он гэхэд дэлхийн усны нөөц 30 хувиар багасах аж. Өөрөөр хэлбэл, 13 жилийн дараа өнөөгийн нийт цэвэр усны гурван литр тутмын нэг литр нь байхгүй болох ажээ. 2025 он гэхэд нэг тэрбум 800 сая хүн усны гачаалд орно гэсэн судалгаа байна. Дэлхийн байгаль хамгаалах сан гурван хүний хоёр нь цэвэр усны дутагдалтай нөхцөлд амьдрахыг анхааруулжээ.

НҮБ гурав дахь мянганы хүн төрөлхтний гамшиг цэвэр усны гачаалаас эхэлнэ гэдгийг анхааруулж, 2005-2015 оныг “Амьдралын эх-Ус” сэдэвт олон улсын 10 жил болгон зарлалаа.

Судлаачид усны гачаал, ургац алдалт, өлсгөлөн, хүнсний хомсдол нүүрлэж, ядуу өмнөдөөс баян хойд руу шилжих их нүүдэл явагдана хэмээн таамаглан бичжээ. Дэлхийн нэр хүнд бүхий хэвлэлүүдэд “дэлхийн цэвэр усны нөөцийг нэмэгдүүлэх ямар ч боломж байхгүй бөгөөд бид цэвэр усны нөөцийг бараг

шавхаж дуусч байна. Дэлхийн цэвэр усны нөөц физик боломжоо шавхахад ойртлоо”, “2025 онд 2 тэрбум хүн уух усгүй, 60 хувь нь гүнзгий гачаал цангаатай байна”, “2025-2030 онд хүн төрөлхтөн түүхэндээ хамгийн аймшигтай сорилттой тулгарч, ундны усны хямралыг амсана”, “нефть, нүүрс, хийгээс гадна эрчим хүчний олон эх сурвалж нээгдэж байна, харин цэвэр усны шинэ эх сурвалж нээх боломжгүй, далайн усыг нэрэх, мөсийг доргиулан цэвэрлэж ашиглах нь дэндүү их эрчим хүчний зардалтай, өндөр өртөгтэй” гэх мэтээр бичиж байна.


ЮНЕСКО-ийн захирал Коитиро Мацуха “усны асуудал ертөнцийн гол хүчин зүйл болно. Энэ зуун усны дайны зуун болохыг хэн ч үгүйсгэхгүй” гэжээ. Түүхэнд уснаас үүдсэн хямрал олон гарч байсан ба сүүлийн 50 жилд уснаас үүдсэн олон улсын маргаан 507 удаа болж, үүний 37 нь зэвсэгт мөргөлдөөнд дөхсөн хурцадмал байдалд хүргэжээ.

Тогтвортой усны ундаргад нэвтрэх боломж хомсдож, хотжилт нэмэгдэж, ирэх 20 жилийн хугацаанд дэлхийн хүн ам 1.2 тэрбумаар нэмэгдэх төлөвтэй байгаагаас ундны усны хүрэлцээ багасах төлөвтэй. Өнөөдөр дэлхийн 21 оронд 600 орчим сая хүн ундны усны хомсдолд ороод байгаа бол хүн амын өсөлтөөс шалтгаалан 2025 он гэхэд 36 орны 1.4 тэрбум хүн ундны усны гачигдалд орох эрсдэл нүүрлээд байна.

Зураг 5. Нэг хүнд ногдох цэвэр усны хэрэглээ: 2025 он хүртэлх төсөөлөл

НЭГ ХҮНД НОГДОХ ЦЭВЭР УСНЫ ХЭРЭГЛЭЭ: 1995, 2025

жилд нэг хүнд ногдох цэвэр усны хэмжээ м3 аар



Эх сурвалж:

International Food Policy Research Institute, Global Water Outlook to 2025.

Хүнсний хомсдол: Хүн амын өсөлт, нийгмийн дундаж давхаргынхны хэрэглээний өөрчлөлтөөс шалтгаалан хүнсний хэрэгцээ 2030 онд 50 хувиар нэмэгдэнэ хэмээн Дэлхийн банк тооцоолжээ. Хөгжиж буй орнуудад амьжиргааны төвшин дээшилж байгаа болон дэлхийн дулаарлаас үүдэн усны нөөц хомсдож

байгаа зэрэг хэд хэдэн хүчин зүйлийн улмаас ойрын ирээдүйд усны хангамжийн асуудал томоохон сорилт болох нь гарцаагүй болов.

Одоогоор дэлхийн 2 тэрбум гаруй хүн хүнсээр гачигдан амьдарч байна. Дэлхийн хүн амын өсөлттэй холбоотойгоор хөгжиж буй орнууд, ялангуяа Африк, өмнөд Азийн орнуудад хүнсний хэрэглээ өссөн, харин хүнсний хангамж буурах төлөвтэй байна. Эрдэмтэд үүнийг тариалангийн талбайн хорогдол, усжуулах системийн хангалтгүй ажиллагаа болон цаг уурын дулааралтай холбон тайлбарлаж байна.

Байгаль орчны доройтол: Дэлхийн хүн ам болон хэрэглээний өсөлт, үйлдвэржилт, түүнээс үүдэлтэй дэлхийн дулаарал, байгаль цаг уур хуурайшиж, ундны ус, ашигт малтмалын нөөц багасч, экологийн сүйрлүүд газар авч, цөлжилт эрчимтэй явагдан, дэлхийн түүхий эд, эрчим хүчний эх үүсвэрийн хэрэгцээ өдрөөс өдөрт өссөөр байна.

Цаг уурын өөрчлөлт, дэлхийн дулаарал нь асар их байгалийн гамшиг, цэргийн мөргөлдөөнийг дагуулах эрсдэлтэй төдийгүй эрчим хүч, хүнс, ундны усны хомсдол нь улс хоорондын дайны шалтаг болж болзошгүй байна.

Терроризм, мөргөлдөөн, үй олноор хөнөөх зэвсгийн дэлгэрэлт: Цөмийн зэвсгийн тархалт нь цөмийн материал террорист бүлгийн гарт орох эрсдэлийг бий болгож байна. Энэтхэг–Пакистаны хооронд өрнөсөөр буй бага хэмжээний мөргөлдөөн нь эдгээр цөмийн зэвсэгтэй гүрнүүдийн хооронд хилийн мөргөлдөөн дэгдэх эрсдэлийг нэмэгдүүлж болзошгүй. Цөмийн зэвсэгтэй зарим орнуудын засаглал солигдох, нуран унах магадлал нь тэдний зэвсгээ хадгалж, хамгаалах чадавхид эргэлзээ төрүүлсээр байна.

Даяаршил, хүчний тэнцвэрийн шилжилт улс орнуудын гол анхаарал болоод буй өнөөгийн ертөнцөд үзэл суртлын гол хүч Араб төвтэй исламын ертөнцөд голлон төвлөрнө хэмээн эрдэмтэд үзэж байна.

Хоёр. Дотоод нөхцөл байдлын талаар

Хүний аюулгүй байдал: Нийгэмд ажилгүйдэл, ядуурал буурахгүй, гэмт хэрэг, архидалт нийгмийн сөрөг үзэгдлүүд нэмэгдэх болсон нь хүн амын дунд бухимдал, гутрал, айдас түгшүүрийг нэмэгдүүлж, сэтгэцийн эмгэг ихсэх эрсдэлийг бий болгож байна. Зуун мянган хүн тутамд амиа хорлосон тохиолдлын тоо жил бүр нэмэгдэж, амиа хорлогсдын дийлэнх хувийг 10-29 насны хүүхэд залуус эзэлж, тэдгээрийн 80 хувь нь эрэгтэйчүүд байна. Насанд хүрэгчдийн 51 хувь нь архийг тогтмол, 12 хувь нь хэтрүүлэн хэрэглэдэг нь судалгаагаар тогтоогдсон байна. Жилд архитай холбоотой золгүй тохиолдлоор мянга орчим хүн нас барж байна. ДЭМБ осол гэмтэл, санаатайгаар хүний эрүүл мэнд, амь насанд аюул учруулж байгаа тохиолдлын 20-30 хувь нь архидалтаас үүдэлтэй гэсэн тооцоог гаргаад байна.

Зөвхөн 2010 онд манай улсад ХДХВ/ДОХ-ын 85 тохиолдол бүртгэгдэв. Монгол Улсад 1992-2004 онд ХДХВ-ын халдварын 5 тохиолдол бүртгэгдэж



байсан бол 2005-2010 онд 79 болтлоо өсөв. НҮБ-ын ДОХ-той тэмцэх нэгдсэн хөтөлбөр болон ДЭМБ-ын 2009 оны тооцоогоор, 2010 оны байдлаар Монгол Улсад 498 хүн ХДХВ-ын халдвартай байх магадлалтай гэжээ. 2015 он гэхэд манай улсад ДОХ-ын улмаас 2500 хүн нас барна гэсэн тооцоог холбогдох байгууллагууд гаргажээ.

Манай улсад хүн худалдах гэмт хэрэг хүүхэд үрчлүүлэх, гадаадад өндөр цалинтай ажил амлах, гадаадын иргэнтэй гэр бүл болоход зуучлах хэлбэрээр үйлдэгдэж байна. Зөвхөн 2008 оны байдлаар Монгол Улсад хүн худалдах гэмт хэрэг 4, биеэ үнэлэхэд бусдыг татан оролцуулах, биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэрэг 19 бүртгэгдэж, 37 хүнд ял шийтгэл ногдуулсан байна. "Хүйсийн тэгш эрхийн төв"-өөр хүн худалдах гэмт хэргийн хохирогч болсон 115 хүн үйлчлүүлсний 32 хувь нь БНХАУ-д, 28 хувь нь Казахстанд, 2 хувь нь Макао, 14 хувь нь эх орондоо хүн худалдах гэмт хэргийн хохирогч болсон байна.

Сүүлийн үед манай иргэд мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар олж авах, хэрэглэх, тээвэрлэх, борлуулах, улсын хилээр нэвтрүүлэх, зөөвөрлөх гэмт хэрэгт холбогдох явдал эрс нэмэгдэж байна. Зөвхөн 2010 оны байдлаар энэ төрлийн 9 гэмт хэрэгт 55 хүн холбогдон шалгагджээ. Мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисыг эргэлдүүлэх бүлэглэлүүд бий болж, улсын хилээр хууль бусаар оруулах, орлогын эх үүсвэр болгох хандлагууд илэрч байна. Залуучууд олс ургамлыг түүж бэлтгэх, мансууруулах бодисын түүхий эд болон зарим төрлийн сул мансууруулах бодисыг нийлэгжүүлж, хүчтэй үйлчилгээтэй хар тамхи гарган авч хэрэглэх болов. Одоогийн байдлаар манай 25 иргэн хар тамхитай холбоотой хэргээр гадаад улс орнуудад ял эдэлж буйгаас БНХАУ-д 15, ОХУ-д 3, бусад нь Казахстан, Малайз зэрэг улсад байна. Тэд үндсэндээ 22-30 насныхан ба ихэнх нь бүх насаар хорих, цаазаар авах, хорих ялаар шийтгүүлжээ.

Хүрээлэн буй орчны аюулгүй байдал: Манай нийт газар нутгийн 77 хувь цөлжилтөд өртсөн, 90 хувь нь цөлжилтөд өртөмтгий, 41.3 хувь нь цөл, цөлөрхөг хээр, хээрийн бүсэд оршдог ба үүний 65.1 хувь нь эрсдэл ихтэй, газрын гадаргын 78 хувь доройтолд орсон байна. Жилээс жилд хүрээгээ тэлж байгаа цөлжилтөд хүний буруутай үйл ажиллагаа, бэлчээрийн талхлагдал, уул уурхай, ой модны зохисгүй хэрэглээ, ус, хөрсний нөөцийн хэт ашиглалт сөргөөр нөлөөлж байна. Малын тоо толгой өсч, бэлчээрийн даац 32.5 хувиар буюу 16 сая толгойгоор хэтэрсэн байна. Сүргийн бүтцэд өөрчлөлт гарч, нийт сүргийн 46 хувийг ямаа эзлэх болсон нь бэлчээрийн талхлагдлын бас нэг шалтгаан болж байна. Зөвхөн газрын уст цэгийн 2007 оны мэдээг 1970 оныхтой харьцуулахад нийт 887 гол, горхи, 2096 булаг, шанд, 1166 нуур, тойром хатаж ширгэжээ. Мөн тариалангийн талбайн заримыг нь огт ашиглахгүй болсноос хөрс сийрэгжиж цөлжилт үүсэх шалтгаан болж байна. Цөлжилтийн нэн хүчтэй, хүчтэй зэрэглэлд Увс нуурын хотгор, Их нууруудын хотгор, Дундговь, Дорноговийн гандуу хуурай, цөлөрхөг нутгууд ихэвчлэн хамрагдаж байна. Говь, хээрийн бүсийн 145 сумын төв суурин

**Түлхүүр үг:** олон улсын харилцаа, дэлхийн улс төр, эдийн засаг, эрчим хүч, хүнс, хүн ам, цэвэр ус, терроризм, мөргөлдөөн, үй олноор хөнөөх зэвсэг, үндэсний ба олон улсын аюулгүй байдал, сорилт, бэрхшээл, зөрчил, мөргөлдөөн.

**Товч хураангуй:** АНУ-ын судлаачид “бидний амьдарч буй эрин үе түүхэнд байгаагүй таамаглахын аргагүй үйл явдлаар дүүрэн цаг үе” хэмээн дүгнэжээ. Энэхүү өгүүллээр олон улсын аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг болсон Монгол Улсын аюулгүй байдлын гадаад, дотоод орчны өнөөгийн байдал, ойрын ирээдүйн төлөв, болзошгүй аюул, сорилт, бэрхшээлийн тухай төсөөллийг толилуулахыг хичээв.

### **ABSTRACT**

According to US researchers' conclusion “we are living in the period that is full of unpredictable developments.” Therefore, this article presents current situation of external and internal environments of Mongolia's National Security, which becomes a part of the international security, and attempts to picture its near-term developments, possible threats, and ordeals.

### **НОМ ЗҮЙ**

1. М.Батчимэг “Шатрын өрөг дэх Монгол” УБ, 2012
2. А.Түвшинтөгс “Хүйтэн дайны дараах Монголын аюулгүй байдлын гадаад орчин”, УБ, 2012
3. Г.Төмөрчулуун “Даяар ертөнц: Монголын геополитик, дипломат ажиллагаа”, УБ, 2009
4. “Жижиг улсын аюулгүй байдал: өнөө, ирээдүй”, Үндэсний тагнуулын академи, УБ, 2010
5. “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг улс төр, дипломатын аргаар хангах нь” эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл, УБ, 2009.